НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/013/НА-СТА-3ГТС


Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Дэд дарга: Ч.Болд
Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү нийцлийн хэлтсийн дарга,
Аудитын менежер: Х.Түвшинбаяр
Утас: Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: С.Гантөгс
Утас: Цахим хаяг: gantugss@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Энхмэнд
Утас: Цахим хаяг: enkhmendn@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзаяа
Утас: Цахим хаяг: ariunzayaba@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.24 № 01/82

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА
Г.БОЛОРСҮХ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 382,565.6 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 4,438,575.2 мянган төгрөгийн авлагын эцсийн үлдэгдэлтэй, үүнээс хугацаа хэтэрсэн 1,530,448.5 мянган төгрөгийн зээлийн авлага байгаагийн 61.8 хувийг шүүхийн байгууллагад, 3.8 хувь нь эвлэрлийн хугацаанд, 9.8 хувийг нас барсан иргэдийн авлага эзэлж байгааг барагдуулах арга хэмжээ авч ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2024 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулан

нийт 1,647,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааг 19 аж ахуйн нэгжтэй нийт 99,025.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрт тусгасан болон тус сангаар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэл, зарцуулалт, хүрсэн үр дүн зэрэг асуудлуудыг аудитын цаг хугацаа, хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитад бүрэн хамруулаагүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.24.BZD.HEDS.docx

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,244,649,381.80** | **4,438,575,179.80** |
| **33** | **АВЛАГА** | 4,244,649,381.80 | 4,438,575,179.80 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 338,471,790.00 | - |
| 33700 | Хөтөлбөртэй холбоотой авлага | 3,904,128,831.80 | 4,406,866,419.80 |
| 33703 | Ажилд зуучлах | 277,090.00 | 277,090.00 |
| 33703 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих | 2,282,272,345.00 | 2,516,258,733.00 |
| 33705 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 634,249,090.00 | 614,920,090.00 |
| 33717 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 422,407,836.80 | 845,060,336.80 |
| 33718 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих | 318,931,270.00 | 238,030,670.00 |
| 33720 | Аймаг, нийслэл, дүүргийн ХЭЗ-с дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл | 237,101,200.00 | 183,429,500.00 |
| 33730 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 8,890,000.00 | 8,890,000.00 |
| 33500 | Бусад авлага | 2,048,760.00 | 31,708,760.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 2,048,760.00 | 31,708,760.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,244,649,381.80** | **4,438,575,179.80** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,244,649,381.80** | **4,438,575,179.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,244,649,381.80 | 4,438,575,179.80 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,244,649,381.80 | 4,438,575,179.80 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,537,528,800.80 | 4,244,649,381.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 707,120,581.00 | 193,925,798.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,244,649,381.80** | **4,438,575,179.80** |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,484,027,000.00** | **3,950,779,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **50,510,000.00** | **46,434,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 50,510,000.00 | 46,434,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 49,250,000.00 | 45,210,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 49,250,000.00 | 45,210,000.00 |
| 120009 | Бусад орлого | 1,260,000.00 | 1,224,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,433,517,000.00** | **3,904,345,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,433,517,000.00 | 3,904,345,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 2,433,517,000.00 | 3,904,345,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,776,906,419.00** | **3,756,853,502.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,776,906,419.00** | **3,756,853,502.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 90,515,710.00 | 63,264,250.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 90,515,710.00 | 63,264,250.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 90,515,710.00 | 63,264,250.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,686,390,709.00 | 3,693,589,252.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 799,522,000.00 | 778,680,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 799,522,000.00 | 778,680,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 48,150,000.00 | 45,210,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48,150,000.00 | 45,210,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 300,000.00 | 1,855,435,940.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 300,000.00 | 1,855,435,940.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 838,418,709.00 | 1,014,262,412.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 838,418,709.00 | 1,014,262,412.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **707,120,581.00** | **193,925,798.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **707,120,581.00** | **193,925,798.00** |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/Төгрөгөөр/*

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,484,027,000.00** | **4,289,251,090.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **50,510,000.00** | **384,905,790.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 50,510,000.00 | 384,905,790.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 49,250,000.00 | 383,681,790.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 49,250,000.00 | 45,210,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 338,471,790.00 |
| 120009 | Бусад орлого | 1,260,000.00 | 1,224,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,433,517,000.00** | **3,904,345,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,433,517,000.00 | 3,904,345,300.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 2,433,517,000.00 | 3,904,345,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,357,378,209.00** | **5,303,513,502.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,357,378,209.00** | **5,303,513,502.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **90,515,710.00** | **63,064,250.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 90,515,710.00 | 63,064,250.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 90,515,710.00 | 63,064,250.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,266,862,499.00** | **5,240,449,252.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,041,522,000.00 | 2,325,540,900.00 |
| 213205 | Тэрээс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,041,522,000.00 | 2,325,540,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 48,150,000.00 | 45,210,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48,150,000.00 | 45,210,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 338,771,790.00 | 1,855,435,940.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 338,771,790.00 | 1,855,435,940.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 838,418,709.00 | 1,014,262,412.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 838,418,709.00 | 1,014,262,412.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(873,351,209.00)** | **(1,014,262,412.00)** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 873,351,209.00 | 1,014,262,412.00 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 873,351,209.00 | 1,014,262,412.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **873,351,209.00** | **1,014,262,412.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/Төгрөгөөр/*

| **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэл-гээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | - | 4,244,649,381.80 | - | 4,244,649,381.80 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **4,244,649,381.80** | **-** | 4,244,649,381.80 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **4,244,649,381.80** | **-** | 4,244,649,381.80 |
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **4,244,649,381.80** | **-** | 4,244,649,381.80 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **4,244,649,381.80** | **-** | 4,244,649,381.80 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 164,265,798.00 | - | 164,265,798.00 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **4,408,915,179.80** | **-** | 4,408,915,179.80 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/Төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,904,345,300.00 | 2,388,605,150.00 | **1,515,740,150.00** | **61.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,904,345,300.00 | 2,388,605,150.00 | **1,515,740,150.00** | **61.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 115,250,000.00 | 63,064,250.00 | **52,185,750.00** | **54.72** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 115,250,000.00 | 63,064,250.00 | **52,185,750.00** | **54.72** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 115,250,000.00 | 63,064,250.00 | **52,185,750.00** | **54.72** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,789,095,300.00 | 2,325,540,900.00 | **1,463,554,400.00** | **61.37** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,789,095,300.00 | 2,325,540,900.00 | **1,463,554,400.00** | **61.37** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,789,095,300.00 | 2,325,540,900.00 | **1,463,554,400.00** | **61.37** |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,904,345,300.00 | 2,388,605,150.00 | **1,515,740,150.00** | **61.18** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,904,345,300.00 | 2,388,605,150.00 | **1,515,740,150.00** | **61.18** |
| 131006 | ЗГ-н тусгай сангаас санхүүжих | 3,904,345,300.00 | 2,388,605,150.00 | **1,515,740,150.00** | **61.18** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 29,660.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулж, нийт 382,565.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 285,244.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 97,321.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** */мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 1 | 29,660.0 | 1 | 29,660.0 | | | 1 | 29,660.0 | | | | |
| **Дүн** | **1** | **29,660.0** | **1** | **29,660.0** | | | **1** | **29,660.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 1 | 8,080.0 | | | | | 1 | 8,080.0 | | | | |
| Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 1 | 87,951.3 | | | | | 1 | 87,951.3 | | | | |
| Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 1 | 1,290.0 | | | | | 1 | 1,290.0 | | | | |
| Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 1 | 255,584.3 | | | 1 | 255,584.3 | | | | | | |
| Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 1 | 29,660.0 | | | 1 | 29,660.0 | | | | | | |
| **Дүн** | **5** | **382,565.6** | | | **1** | **285,244.3** | **3** | **97,321.3** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 1 | 80,844.0 | | | | | 1 | 80,844.0 |
| Дүн | **1** | **80,844.0** | | | | | **1** | **80,844.0** |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ЗГТС | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |